



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар #1544

Арвайхээр


Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн а/788 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн Засаг даргаас олгох шагналын журмыг шинэчлэн батлах тухай” журмын 2.4, 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орчин цагийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхт 100 жилийн ойг тохиолдуулан төрийн тусгай байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээл гарган ажиллаж байгаа хөдөлмөр зүтгэлийг нь үнэлж Өвөрхангай аймгийн Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс 423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн сургалт, хүний нөөц, хэвлэл мэдээлэл, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, ахмад Э.Пүрэвсүрэн (РЖ87020505), тус ангийн хамгаалалтын ажилтан сургагч, ахлагч А.Ган-Эрдэнэ (ЙР82071674) мөн тус ангийн хамгаалалтын ажилтан, ахлах ахлагч Д.Нарандорж (ЙР77090811), Өвөрхангай аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ээлжийн дарга, хошууч Мөнхбатын Түвшинзул (ЙЮ82021814), тус газрын жолооч, ахлах ахлагч Сүхбаатарын Дашдорж (ЙР80101017) нарыг “Аймгийн Засаг даргын жуух бичиг”-ээр тус тус шагнасугай.

2.Шагналд дагалдах тус бүр 30.000 (гучин мянга), нийт 150.000 (нэг зуун тавин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101158